



**БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас: 7034-2938

Цахим шуудан: www.info@bulgan.gov.mn
Цахим хуудас: www.bulgan.gov.mn

2025-05-27 № 03/807
танай 2025.0424 ны № 185/1122 т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА, НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Н.УЧРАЛ
ТАНАА**

Бид нээлттэй засгийн түншлэлийн хүрээнд
“Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” 2025 арга
хэмжээг төр хувийн хэвшлийн оролцоог ханган 2025 оны
05 дугаар сарын 19-ний өдрөөс 23-ны өдрийг хүртэл
аймагтаа зохион байгууллаа.

“Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” 2025
арга хэмжээний тайланг хавсралтаар хүргэж байна.

Хавсралт... хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНБАЯР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/ЗДТГ-А5

6325080474

**“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ - 2025” АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

Булган аймаг

2025.05.23

ОГНОО	АРГА ХЭМЖЭЭ (Булган аймаг)	Хариуцсан алба хэлтэс /Зохион байгуулагч/	Хамрах хүрээ /Оролцогчид/
2025.05.19 (Даваа)	Нээлттэй засгийн түншлэлийг таниулан сурталчлах, долоо хоногийн арга хэмжээ зохион байгуулах тухай өөрийн харьяа хэвлэл мэдээллийн сувгаар түгээж төлөвлөсөн арга хэмжээний тухай мэдээлэх	Аймгийн Тамгын газрын хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах алба	Булган аймгийн нийт иргэд
2025.05.20 (Мягмар)	Нээлттэй засгийн түншлэлийн 10 үнэт зүйлийн хүрээнд нээлттэй өдөрлөг зохион байгуулах	Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	Булган сумын иргэд, бизнес эрхлэгчид
2025.05.21 (Лхагва)	СЕХ-той хамтран “Нээлттэй засгийн сорилт: Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал” арга хэмжээг зохион байгуулах	Аймгийн Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс	Аймагт үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намын төлөөлөл /МАН, АН, ХҮНам/
2025.05.22 (Пүрэв)	НҮБХХ-тэй хамтран “Бизнес ба хүний эрх” сургалтыг цахимаар зохион байгуулах	Аймгийн Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс	Аймгийн ИТХ-ын дарга, Нарийн бичгийн дарга, Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар, бодлогын мэргэжилтнүүд
2025.05.23 (Баасан)	Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног арга хэмжээний хаалт	Төрийн захиргааны удирдлгын хэлтэс	Тамгын газрын дарга, ХЭЗХ-ийн дарга, БОНХОБТХ-ийн мэргэжилтэн, ТЗУХ-ийн мэргэжилтэн, Булган аймаг дахь ТЦҮХ-ийн дарга

Даваа гараг: Аймгийн тамгын газрын албан ёсны вэб сайт www.bulgan.gov.mn болон фэйсбүүк пэйж хуудсаар “Нээлттэй засгийн түншлэлийг таниулан сурталчлах, долоо хоногийн” арга хэмжээ 5 өдрийн турш зохион байгуулагдах үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт дараах хаштагуудыг (**#OpenGoWeek #OpenGoChallenge #OPG # OpenGov #Mongolia #OGPActionPlan**) ашиглан сурталчлах, таниулах, арга хэмжээг зохион байгуулж ажиллаа.

Үүний үр дүнд төрийн албан хаагчид, иргэд, бизнес эрхлэгчид нээлттэй засгийн түншлэлийн тухай мэдлэг, ойлголттой болсон болно.

Мягмар гараг: Нээлттэй засгийн түншлэл нь нээлттэй засгийг дэмжих, авлигатай тэмцэх, засаглалыг бэхжүүлэх чиглэлээр Засгийн газруудын амлалтыг баталгаажуулах зорилгоор 2011 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдааны үеэр албан ёсоор хэрэгжиж эхэлсэн санаачилга бөгөөд үүсгэн байгуулагч 8 улсын Засгийн газрын тэргүүн нар Нээлттэй засгийн тунхаглалыг дэмжиж, улс орныхоо үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах үүрэг, амлалтыг олон нийтэд зарласан. Ийнхүү үүсгэн байгуулснаас хойш тус түншлэлд 77 улс орон, 150 орон нутгийн дэмжих нэгж, олон мянган иргэний нийгмийн байгууллагууд нэгдсэн.

Нээлттэй засгийн түншлэлд Монгол Улс 2013 онд нэгдэн орсноос хойш олон улсад өгсөн үүрэг, амлалтыг хэрэгжүүлж, гишүүн улсын хувьд Нээлттэй засгийн түншлэлийн үнэт зүйлсийг бэхжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх, ялангуяа нийгмийн эгэх хариуцлага, ил тод байдал, нээлттэй байдал, сан ёс, шударга ёс, иргэний орон зайн асуудлаар хамтран ажиллах боломж, бололцоог эрэлхийлж ирсэн.

Иймд "Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног" арга хэмжээг Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс Булган аймгийн ААН, Хувиараа бизнес эрхлэгчид, Иргэд, Хоршооллын гишүүдэд хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, авлигын эсрэг тэмцлийг эрчимжүүлж, төрийн хэт оролцоо, хүнд суртлыг арилгах зорилгоор "И- Бизнес" бизнес эрхлэгчдэд зориулсан платформыг таниулан сурталчлах чиглэлээр “ӨДӨРЛӨГ” зохион байгууллаа.

Зорилго: "Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног 2025" арга хэмжээний зорилго нь Нээлттэй засгийн түншлэлийн үнэт зүйлсийг бэхжүүлэхэд хамтын ажиллагааг өргөжүүлэх, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх."И-Бизнес" бизнес эрхлэгчдэд зориулсан платформыг таниулахад оршино.

Өдөрлөгийн үеэр:

- Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтан Д.Өлзийчимэг “И-Бизнес” платформын танилцуулга
- Үйлчилгээний ажилтан Н.Ганцолмон “Мэдээллийн аюулгүй байдал ба кибер халдлага, хэрхэн урьдчилан сэргийлэх” сэдвээр мэдээлэл

- Монголын Цахилгаан Холбоо ТӨХК-ийн Булган аймаг дахь салбарын захирал Т.Золзаяа “Тоон гарын үсгийг хэрхэн авах, ашиглах тухай” зөвлөмжийг тус тус өгсөн юм.

Хавсралт зураг №1





Лхагва гараг: Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлын талаарх мэдээлэл болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуультай холбоотойгоор аймагт үйл ажиллагаа явуулдаг гэж Монгол ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам, Иргэний хөдөлгөөний нам, Сайн ардчилсан иргэдийн намуудын удирдлагуудтай холбогдохоор оролдсон боловч ХҮН нам, Иргэний хөдөлгөөний намуудтай холбогдож чадаагүй болно.

Уулзалтад Монгол ардын нам, Ардчилсан намын төлөөлөл биечлэн ирж, Сайн ардчилсан иргэдийн намын төлөөлөлтэй цахимаар холбогдон мэдээлэл өгч, харилцан санал солилцон ажиллалаа.

Хавсралт зураг №2



Пүрэв гараг: Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулж буй “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног - 2025” арга хэмжээний хэсэг болох **хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх** зорилгын хүрээнд Европын Холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Өөрчлөлтийн элч төлөөлөгчид: Хариуцлагатай бизнесийн төлөөх залуус ба хэвлэл мэдээлэл” төслөөс зохион байгуулсан сургалтад улсын хэмжээнд 150 гаруй оглайнаар оролцож, Булган аймгийн ИТХ-ын дарга, Хурлын нарийн бичгийн дарга, аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга, Хууль эрх зүйн хэлтсийн

мэргэжилтэн, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга мэргэжилтнүүд, ТЗУХ-ын мэргэжилтнүүд суурин компьютер болон гар утсаараа орж дараах сэдвийн хүрээнд мэдлэг мэдээллээр хангагдав.

- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 онд баталсан “Бизнес ба хүний эрхийн Удирдах Зарчмууд”,
- Монгол Улсын Засгийн газраас 2023 онд 231 тоот тогтоолоор баталсан “Бизнес ба хүний эрх” Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулга,
- НҮБ Бизнес ба Хүний эрхийн Удирдах зарчмуудын 1-р тулгуур багана болох Хүний эрхийг хамгаалах Төрийн үүрэг зэрэг болно.

Баасан гараг: Нээлттэй засгийн түншлэлийн 7 хоног 2025 үйл ажиллагааны хаалтыг ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамт Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн видео бичлэгийг онлайнаар үзэн танилцаж, өнгөрсөн өдрүүдэд зохион байгуулсан арга хэмжээнүүдээ дүгнэж, иргэд олон нийт, төрийн албан хаагчид Нээлттэй засаглалын түншлэлийн талаар тодорхой хэмжээний мэдлэг ойлголттой болсон гэж дүгнэлээ.

Хавсралт зураг №3



ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Д.ЭРДЭНЭБИЛЭГ

/Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга/

ТАЙЛАН БИЧСЭН:

Б.ЭНХМАА

/Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн/